



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2014 оны 03 сарын 03 өдөр

Дугаар 73

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2010 оны 141 дүгээр тогтоолоор батлагдсан “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах” үндэсний хөтөлбөрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Ази номхон далайн цахилгаан холбооны байгууллагын “Цахим аюулгүй байдлын 5 дугаар форум”-ыг 2014 оны 5 дугаар сарын 26-наас 28-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулахтай холбогдуулан тус арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Ажлын хэсгийн үйл ажиллагааг удирдамжийн дагуу зохион байгуулж, үр дүн, тайланг газрын удирдлагад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Ч.Нургул/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЖАДАМБАА

110763

Мэдээлэлийн технологи, шуудан, харилцаа холбооны
газрын даргын 2014 оны 03 сарын 05 өдрийн 73 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

УХА0514 5202965

АЖЛЫН ХЭСГИЙН ЕРӨНХИЙ УДИРДАМЖ

Зорилго: Ази номхон далайн цахилгаан холбооны байгууллагын “Цахим аюулгүй байдлын 5 дугаар форум” зохион байгуулах


Хугацаа: 2014 оны 3 дугаар сарын 03-наас 2014 оны 5 дугаар сарын 30-ны өдөр хүртэл

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Бэлтгэл ажлын төлөвлөгөө гаргах /Зохион байгуулах газар сонгох, гэрээ байгуулах, зардлын төсөв гаргах, гадаадын зочдын виз гэх мэт/
2. Ажлын төлөвлөгөөний дагуу ажил үүргийг гишүүдэд хуваарилах
3. АНЦХБ-тай хамтран ажиллах /Мэдээллээр хангах, оролцох төлөөлөгчдийн нэрсийг гаргах/
4. Форумын арга хэмжээг ивээн тэтгэгч байгууллагуудтай хамтран ажиллах
5. Форумын ажиллагаанд оролцох төрийн байгууллагуудтай хамтран ажиллах
6. Форумын үйл ажиллагааг Засгийн газарт танилцуулах бэлтгэлийг хангах, олон нийтэд сурталчлах
7. Форумын үйл ажиллагааг зохион байгуулах

Тайлан: Ажлын хэсгийн үйл ажиллагааны тайланг гаргаж 2014 оны 6 дугаар сарын 09-ний өдөр газрын удирдлагад танилцуулна.

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын даргын 2014 оны 23 сарын 23 өдрийн 23 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:		
Ч.Нургул	Харилцаа холбоо, дэвшилтэт технологийн ажлын албаны ахлах мэргэжилтэн	
Нарийн бичгийн дарга:		
Б.Гэрэлсүрэн	Шинэчлэлийн бодлого, төлөвлөлтийн газрын Мэдээллийн технологи, инновацийн хэлтсийн мэргэжилтэн	
Гишүүд:		
Б.Цэцэг	Хяналт, шинжилгээний газрын ахлах мэргэжилтэн	
П.Ариунтуул	Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын мэргэжилтэн	
Б.Болормаа	Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын мэргэжилтэн	
З.Болормаа	Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын мэргэжилтэн	
Н.Бат-Энэрэл	Харилцаа холбоо, дэвшилтэт технологийн албаны мэргэжилтэн	
Г.Нэргүй	Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын мэргэжилтэн	
Ц.Пүрэвням	Шинэчлэлийн бодлого, төлөвлөлтийн газрын Мэдээллийн технологи, инновацийн хэлтсийн мэргэжилтэн	
Ё.Оюун-Эрдэнэ	Шинэчлэлийн бодлого, төлөвлөлтийн газрын Сансар, радио холбооны хэлтсийн мэргэжилтэн	
Э.Энхбат	Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн	
Ц.Одхүү	Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн	